



ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36 дугаар тушаал, 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1а/545 тоот албан даалгавар, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагаан сар билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3-ны баярын өдрүүдэд 3 хоног амрахтай холбогдуулан Эмнэлгийн тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх, чанар, аюулгүй байдал алдагдах, халдварт өвчний дэгдэлт, томуу, томуу төст өвчин, олныг хамарсан осол аваар, хөлдөлт, осголт, түлэгдэлт, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах зорилгоор байгууллагын хариуцлагатай жижүүрийг 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл 24 цагаар ажиллуулсугай.
2. Хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэх албан хаагчдын нэрс, хуваарийг нэгдүгээр, Салбар эмнэлгийн хариуцлагатай жижүүрийн нэрс хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Эмнэлгийн яаралтай тусламж, сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасаг, нэгжийн ор, хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүний бэлэн байдал, тасалдалгүй хангах, нөхөн хангалтыг шуурхай зохион байгуулахыг тасаг, албадын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.
4. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хариуцлагатай жижүүрт тухайн өдрийн мэдээг дараа өдрийн 09:00-10:00 цагийн хооронд hsic2004@hdc.gov.mn цахим хаягаар илгээх ба холбогдох маягт Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалаар батлагдсан “Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэдээлэх бүртгэл” АМ-36, “Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас” АМ-33 маягтын дагуу өдөр бүрийн 08:00, 22:00 цагт (өссөн дүнгээр) нийтийг хамарсан хордлого, осол гэмтэл, халдварт өвчний дэгдэлтийн мэдээллийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэхийг Статистик, тандалт судалгааны алба (Б.Түмэн-Өлзий), Хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэж буй эмч, ажилтнуудад тус тус даалгасугай.
5. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний ноцтой алдаа, зөрчил гарсан үед болон жижүүр эмч нарын мэдээг өдөр бүрийн 08 цагт цахим хэлбэрээр явуулахыг Эмнэл зүй хариуцсан дэд захирал (Р.Гантуяа), Салбар эмнэлгийн Эмнэл зүй хариуцсан дэд захирал (О.Хишигсүрэн), Эмнэлгийн тоног төхөөрөмж, хүчилтөрөгчийн нөөц, цахилгааны эх үүсвэр, автомашин, шатахууны бэлэн байдлыг ханган ажиллахыг Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал (Б.Батзориг) нарт тус тус хариуцуулсугай.
6. Хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчид, хуваарийн дагуу ажиллаж байгаа удирдах болон эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд холбогдох албан даалгаврыг мөрдлөг болгох, утсаа нээлттэй байлгаж, яаралтай журмаар дуудсан тохиолдолд

2024.4.8

шуурхай ирж бэлэн байдал хангаж ажиллахыг нийт эмч, эмнэлгийн ажилтнуудад өрөө тасалгааны ус цахилгааны хэвийн үйл ажиллагааг 2 хоног тутамд шалгахыг нийт тасаг, албадын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.


7. Тушаалыг хамт олонд танилцуулж, бүх нийтийн баярын амралтын өдрүүдэд ажилласан эмч, эмнэлгийн ажилтнууд, хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн ажилтнуудыг холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн амруулах болон илүү цагаар тооцон олгох зохион байгуулалтыг авч хэрэгжүүлэхийг Хүний нөөцийн алба (А.Цэрэндолгор), Санхүү бүртгэлийн алба (Ц.Энхбаяр), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Эмнэл зүй хариуцсан дэд захирал (Р.Гантуяа) нарт тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ



Э.ГАЛБАДРАХ

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн
захирлын 2024 оны 2 сарын 8-ны
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ
АЖИЛЛАГСДЫН НЭРС**

№	Нэр албан тушаал	Холбоо барих утас	Хяналт тавих	Ажилах он сар өдөр	Ажиллах цаг
1	ХНА-н архивын ажилтан Э.Янжинлхам	94916295	А.Цэрэндолгор Хүний нөөцийн албаны дарга 99155499	2024.02.09- 2024.02.10	17 ³⁰ -08 ³⁰
2	ЭМДЗА-ны Даатгалын их эмч Г.Батбямба	95340435	Б.Мөнхдөл Эрүүл мэндийн даатгал зохицуулалтын албаны дарга 99740015	2024.02.10- 2024.02.11	08 ³⁰ -08 ³⁰
3	ЭМДЗА-ны Даатгалын их эмч Ц.Оюунболд	99332425	Д.Азбаяр Клиник эм зүйн албаны дарга 90220022	2024.02.11 2024.02.12	08 ³⁰ -08 ³⁰
4	ЭМТҮЧАБА-ны чанарын менежер Б.Билгүүн	99601264	Т.Сүхболд Халдварын сэргийлэлт хяналтын албаны дарга 89980312	2024.02.12- 2024.02.13	08 ³⁰ -08 ³⁰

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн
захирлын 2024 оны 2 сарын 08-ны
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**САЛБАР ЭМНЭЛГИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГСДЫН НЭРС**

№	Нэр албан тушаал	Холбоо барих утас	Хяналт тавих	Ажилах он сар өдөр	Ажиллах цаг
1	ЭЭТ-н Ахлах сувилагч Ө.Лайла	94720105	Ч.Ууганбаяр Эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч 86080308	2024.02.09- 2024.02.10	17 ³⁰ -08 ³⁰
2	СГТ-н Ахлах сувилагч М.Пүрэвсүрэн	94029990	С.Батсүх Спортын гэмтлийн төвийн тасгийн эрхлэгч 99180749	2024.02.10- 2024.02.11	08 ³⁰ -08 ³⁰
3	СЗЭТ-н Ахлах сувилагч Т.Алтанзаяа	80001012	Г.Ууганбаяр Сэргээн засах эмчилгээний тасгийн эрхлэгч 99065775	2024.02.11 2024.02.12	08 ³⁰ -08 ³⁰
4	ЯЭМЗТ-н Ахлах сувилагч Э.Эрдэнэцэцэг	99721998	О.Цэрэндорж Нөхөн сэргээх мэс заслын тасгийн эрхлэгч 99898100	2024.02.12- 2024.02.13	08 ³⁰ -08 ³⁰